



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/439

Булган сум

**Аймаг, сумын баяр наадам тэмдэглэн
өнгөрүүлэх хугацаа тогтоох тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Нийтээр тэмдэглэх болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 245 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2235 жил, Их Монгол Улсын 820 жил, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 105 жилийн ой, Булган аймаг үүсгэн байгуулагдсаны 88 жилийн ойн баяр наадмыг 2026 оны 07 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сумдын баяр наадмыг 2026 оны 07 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулж, Түүхт болон тэмдэглэлт ойтой сум, байгууллагын баяр наадмын хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Аймаг, сумдын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, Үндэсний их баяр наадмыг угтсан тохижилт, бүтээн байгуулалт, соёлжилтын ажлыг эрчимжүүлэн зохион байгуулж ажиллахыг аймгийн баяр наадмыг зохион байгуулах хороо, сумдын Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 18-ны/ний өдрийн
А/439 дугаар захирамжийн хавсралт

ТҮҮХТ БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ОЙТОЙ СУМ,
БАЙГУУЛЛАГЫН БАЯР НААДМЫН ХУВААРЬ

д/д	Сум, Байгууллага	Тайлбар	Ой тэмдэглэн өнгөрүүлэх хугацаа
1	2	3	4
1	Баяннуур сум	Цогт Хунтайжийн мэндэлсний 445 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх	08 дугаар сарын 15
2	Хангал сум	Монгол Улсын Даяар дурсагдах Далай, Даян, Дархан аварга, Үндэсний спортын ууган гавьяат мастер Б.Түвдэндоржийн мэндэлсний 110 жил, Монголын нэрт эрдэмтэн толь зүйч, төвдөч эрдэмтэн Б.Шагжийн мэндэлсний 140 жил, Түмэн адууны баярыг тэмдэглэн өнгөрүүлэх	07 дугаар сарын 21-23
3	Хишиг-Өндөр сум	Түшээт хан аймгийн Бишрэлт гүн Д.Сундуйн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх	07 дугаар сарын 3,4
4	Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн төв үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай	07 дугаар сарын 31, 08 дугаар сарын 01
5	Онцгой байдлын газар	Булган аймаг дахь Гал унтраах, аврах 20 дугаар анги, Хангал сумын Хялганат тосгоны Гал унтраах, аврах 50 дугаар ангийн 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх	07 дугаар сарын 24,25 07 дугаар сарын 17,18

--o00o--